



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/343

Хэрлэн сум

Газар ашиглалтын зориулалт  
өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын 8.1.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын иргэн Гэндэнжамц овогтой Доржнамжимын (РД:СЮ59031804) гаргасан хүсэлтийн дагуу Хэрлэн сумын 2 дугаар баг Өргөө 9-04 тоотод байршилтай 976 м2 амины орон сууцны зориулалттай өмчлөлийн газрын өмчлөх эрхийг дуусгавар болгож тус газар ашиглалтын зориулалтыг өөрчилж Үйлчилгээтэй орон сууцны зориулалтаар 60 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Б.Сүнгээ)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн (Г.Доржнамжим)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн Газар өмчлүүлэх тухай А/149 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ